

ДеФакто **ТОЙМ**

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН **ХОРИГИЙГ** УИХ ХҮЛЭЭЖ **АВСАНГҮЙ**

Төсөв өөрөө эдийн засгаас хамаардаг тул хөнжлийнхөө хэрээр хөлөө жийх гэсэн зарчмыг баримталдаг. Монгол улс 2012-2016 онд гурван ч төсөвтэй болсон байлаа...

VI НҮҮРТ

ДеФакто **ЯРИЛЦЛАГА**

Ц.ЭНХ-АМГАЛАН
**25 ЖИЛИЙН ТУРШ
БЭЛЧЭЭРИЙН ХУУЛИЙН
ТУХАЙ ТӨСӨЛ
УИХ-Д УДАА ДАРАА
ӨРГӨН БАРИГДААД
ОДООГ ХҮРТЭЛ
ХЭЛЭЛЦЭГДЭЭГҮЙ,
БАТЛАГДААГҮЙ БАЙНА**

IV НҮҮРТ

ДеФакто **НИЙТЛЭЛ**



ТӨРИЙН ЗӨГНӨЛТ РОМАН:
СТРАТЕГИЙН ОРД

II НҮҮРТ

The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ

ЗОРИГЖУУЛНА

МЭДЭЛЖҮҮЛНЭ

Лхагва, 2017.12.13, №25

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХАРААТ БУС, БИЕ ДААСАН ДОЛОО ХОНОГ ТУТМЫН СОНИН

www.defacto.mn

Төрийн зөгнөлт роман:

СТРАТЕГИЙН ОРД

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар “Тогтвортой хөгжилд уул уурхай” сэдэвтэй үндэсний зөвлөгөөнийг өнгөрөгч Баасан гарагт нийслэлд зохион байгуулав. Уул уурхай ба дэд бүтцийн талаар хэлсэн үгээ би үүгээр толилуулж байна.

Үргэлжлэл II НҮҮРТ





№ 409

Дамбадаржаагийн **ЖАРГАЛСАЙХАН**

Долоо хоног бүрийн нийтлэл,
<http://jargaldefacto.com/category/23>

Төрийн зөгнөлт роман:

СТРАТЕГИЙН ОРД



Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар “Тогтвортой хөгжилд уул уурхай” сэдэвтэй үндэсний зөвлөгөөнийг өнгөрөгч Баасан гарагт нийслэлд зохион байгуулав. Уул уурхай ба дэд бүтцийн талаар хэлсэн үгээ би үүгээр толилуулж байна.

АНУ-д төвтэй “Mining Journal” Дэлхийн эрсдлийн 2017 оны тайландаа монголын дэд бүтцийг “хамгийн сул хөгжсөн, эрсдэл өндөр” гэж дүгнэжээ. Тайланд уул уурхайн томоохон тоглогч 85 хуулийн этгээдийг 3600 үзүүлэлтээр шинжээд, хөрөнгө оруулалтын эрсдлийг 1-100 оноогоор дүгнэж, AAA-DDD-гийн хооронд эрэмбэлжээ. Канадын таван муж, АНУ-ын

Аляска, Швед улс наyas дээш оноо авч AAA, хамгийн бага эрсдэлтэй, Лаос болон Гвиней дөчөөс доош оноо авч D, хамгийн эрсдэлтэй, Монгол 53 оноо CCC авч “өндөр эрсдэлтэй” орноор шалгарчээ.

Монголын эрх зүйн орчинг-49, засаглалыг-64, нийгмийн зөвшөөрлийг-66, санхүүгийн орчинг-52 оноогоор тус тус үнэлжээ. Харин дэд бүтцийг 11 оноогоор (төмөр зам 7, эрчим хүчний баталгаа 15) үнэлж хамгийн сул хөгжсөн болохыг онцолжээ. Энэ бол тэдний дүгнэлт. Харин бид өөрсдөө яаж дүгнэж байна вэ?

ДЭД БҮТЦИЙН ДЭНДСЭН ЗӨГНӨЛ

МУ том газар нутагтай, цөөн хүн амтай учраас зам тээвэр, эрчим хүчний дэд бүтэц байгуулахад өртөг өндөр, эргэн төлөгдөх хугацаа урт. Энэ бол биднээс хамаарахгүй, бодит хүчин зүйл. Харин биднээс хамаарах хүчин зүйл бол ухаалаг бодлого хэрэгжүүлж, хүн ард нь хөдөө хотгүй сайхан амьдрах боломжийг бүрдүүлэх явдал. Бодлого нь зөв, тэгээд тасралтгүй явбал зорьсон газраа хүрдэг.

Харин манай бодлого нь буруу учраас эдүгээ дэд бүтцээ ч байгуулсангүй, эдийн засгийн хөгжил саарч, хөдөө эзгүйрч байна. “Мянганы зам” төслийн алсын хараа нь зөв учир

удаан ч гэсэн яваад л байна. Харин “Стратегийн орд” гэх алсын харааг иргэд ч сайн ойлгосонгүй, эрх баригчид ч өөрсдийнхөө ашиг сонирхолд тохируулан ашигладаг болсноос, уул уурхайн салбар хөгжлийн зүтгүүр болохгүй байна. Стратегийн орд гэсний цаад санаа бол уг нь уул уурхайгаа дагуулаад дэд бүтцээ хөгжүүлэх зорилготой байжээ.

Ашигт малтмалын тухай 1997 онд гарсан анхны хуулиа 2006 онд шинэчилсэн. Түүнээс хойш энэ хуулийг 250 удаа буюу дунджаар хоёр долоо хоног тутам өөрчилж иржээ. Үүнээс зөвхөн хоёр өөрчлөлтийг нь харъя.

Эхнийх нь 2007 оны 2-р сарын 6-нд (М.Энхболдын

Засгийн газар) Их Хурлын 27-р тогтоолоор шинэ нэр томъёог оруулжээ. Хуулийн 4.1.12 зүйлд “стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд” гэж үндэсний аюулгүй байдал, улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд нөлөөлөх хэмжээний, эсхүл жилд Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний таван хувиас дээш хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа буюу үйлдвэрлэх боломжтой” ордыг хэлэх болов.

Хоёр жилийн дараа 2009 оны 1-р сарын 8-нд УИХ (С.Баярын Засгийн газар) энэ хуулийн 5.5-р зүйлд.



“Улсын төсвийн оролцоогүйгээр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг эзэмшигчийн тухайн ордод оруулсан хөрөнгийн 34 хүртэлх хувьтай тэнцэх хувьцааг төр эзэмшиж болох бөгөөд уг хэмжээг төрөөс оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан орд ашиглах гэрээгээр тодорхойлно. Уг гэрээгээр тогтоосон төрийн эзэмшлийн хувь, хэмжээг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулж болно” гэж өөрчлөв.

Төр гадаадын компанийн нээсэн орд газарт давуу эрхтэйгээр оролцох тухай хууль, жишээ нь Орост байдаг. Гэхдээ төр хувьцаа эзэмшинэ, түүнийг худалдан авна, үнийг нь нөөц ашигласны төлбөрөөсөө суутгуулж, дээр нь бас нэмж хүү төлнө гэж зөвхөн монголын төр засгийн түшээд л “зөгнөж” чаджээ. Улмаар шууд авч эхлэх байсан төлбөрийнхөө

талыг нь хойшлуулж, ногдол ашгаа бүх зээл, хүүгээ барагдуулсны дараа, олон арван жил болоод авахаар буюу тэмээн дээр, ямаагаа өгсөн нь чухам хэнд ашигтай байсан юм бол?

Нэгэнт л өөрийн хүсэлтээр мөнгөө авахаа хойшлуулсан учир, төр засаг нь гадаадаас зээл авахын тулд гоё, гоё нэртэй өрийн бичиг [бонд] гаргав. Тэгээд бондын зээлээ төлөх цаг нь ирэхээр, өмнөхөөсөө өндөр хүүтэй, урт хугацаатай зээл шинээр авч, бүр гоёор нэрлээд, хуучин зээлээ барагдуулж байна. Монгол улс зээлээс зээлийн хооронд тарчиг ядуу амьдрах болов.

Уул уурхайгаасаа баяжсан Австрали, Канад зэрэг улсын төр нь ямар ч орд газрын, ямар ч хувьцаа эзэмшдэггүй атлаа авах ёстой мөнгөө эхнээс нь, цагт нь аваад, олборлогч бүх компаниудын үйл ажиллагааг нь бүрэн хянаж, хууль дүрмээ мөрдүүлж чаддаг ажээ.

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ХОТ БАЙГУУЛАХ ГЭЖ БИШ, АШИГ ОЛОХ ГЭЖ ИРДЭГ

Социалист улсад уул уурхайн орд газрыг дагуулаад хот тосгон байгуулж, иргэдээ хүчээр суурьшуулж болдог. Тоталитар оронд бүх зүйл хамтын буюу хэний ч өмч биш байдаг. Нийгмийн дэд бүтцийг төрөөс байгуулж, үйл ажиллагааны зардлыг нь олборлогч компаниар нь даалгуулаад л боллоо. Тэр компани ч бас төрийн өмч. Яг энэ замаар жишээ нь Эрдэнэт хотыг байгуулсан.

Харин зах зээлийн эдийн засагт хувийн хэвшил юу хийхээ өөрөө шийддэг. Монголд хөрөнгө, мөнгө хүрэлцэхгүй байгаа тул төр засаг нь гадаадын хувийн компанийг гуйж, хөрөнгө оруулалт хийхийг уриалж байна.

Гадаадын компани уул уурхайн салбарт хөрөнгө оруулж эрдэс баялгийг хайж, олборлож, боловсруулж, борлуулан ашиг олох гэж орж ирж байгаа болохоос, хот байгуулах гэж ирдэггүй юм.

Харин баялгийн эзэн улс уурхайгаас авах ёстой төлбөрөө эхнээс нь бүрэн аваад хотоо барина уу, тосгоноо барина уу, тухайн улсын хувийн хэрэг юм. Гэхдээ юугаа, яаж барихаа орон нутгийн иргэдтэй зөвлөлдөж шийдэх учиртай. Уул уурхайн хотхонд хүнийг хүчээр суурьшуулах боломжгүй. Бид тэгэхээр ашигт малтмал ашигласны төлбөрөө эхнээсээ бүрэн аваад түүгээрээ шинээр хот барих уу, эсвэл байгаа аймаг, сумын аль нэг төвөө хөгжүүлэх үү гэдгээ өөрсдөө шийдэх ёстой. Тэгэхдээ шинэ хотын амьдрал зөвхөн тухайн орд газраас хамаардаггүй, хүн амын бүх хэрэгцээг хангахуйц үйлчилгээтэй, бусад бизнесийг хөгжүүлэх боломжтой байж л уурхайн нөөц дуусахаар “сүнс хот” болж хаягддаггүй юм аа.

Стратегийн орд газартай болсон биш төрийн өмчийн олон компани бий болж, бүгд алдагдалтай ажиллаж, төсвийн мөнгөөр татаас авч байна.

Алдагдалтай учир, юун дэд бүтэц байгуулах, харин ч сургууль, эмнэлэг барих төсвийн хөрөнгийг сорох болов. Стратегийн ордууд хөгжил биш өр авчирлаа. Монгол өнөөдөр гадаад, дотоодын өрөндөө живчихээд байна.

Дэд бүтцийг уг нь бондын мөнгөөр биш, 30-40 жилийн хугацаатай, жилийн 1-2 хувийн хүүтэй хөгжлийн банкуудын зээлээр барьдаг. Манай эрх баригчид үүнийг сайн мэдэж байгаа ч, хатуу нарийн хяналттай энэ зээлийг авахын оронд арилжааны бонд гарган зээлийн хөрөнгийг өөрсдөдөө ашигтайгаар хуваарилсан юм.

Өөрсдийнх нь компани оролцоогүй л бол эрх баригчид дэд бүтцийн ямар ч том төслийг явуулахаа больжээ. 5-р цахилгаан станцыг барих гэж 10 удаа шавыг нь тавьсан нь үүнийг батлаж байна. ОТ импортолж буй эрчим хүчийг өөрсдөө хангаж байгаа бол хамгийн ашигтай, бэлэн худалдан авагчтай учир өдийд нэлээд орлого олох байлаа.

Монголын төр “Стратегийн орд” гэх зөгнөлөөрөө хэзээ хүртэл “чулуу хөөлгөх” юм бол оо?

2017.12.13





Ц.ЭНХ-АМГАЛАН

“Ногоон алт” бэлчээрийн экосистемийн удирдлага төслийн менежер

ДеФакто ЯРИЛЦЛАГА

Монгол, англи, орос хэл дээрх ярилцлага, <http://jargaldefacto.com/category/8>

25 ЖИЛИЙН ТУРШ БЭЛЧЭЭРИЙН ХУУЛИЙН ТУХАЙ

ТӨСӨЛ УИХ-Д УДАА ДАРАА ӨРГӨН БАРИГ ДААД ОДООГ ХҮРТЭЛ ХЭЛЭЛЦЭГДЭЭГҮЙ, БАТЛАГДААГҮЙ БАЙНА

Ц.Энх-Амгалан нь хөдөө аж ахуйн эдийн засагч мэргэжилтэй бөгөөд Их Британийн Манчестр хотын Их сургуульд нийгэм судлал, хөгжлийн эдийн засгийн чиглэлээр магистр, Швейцарь улсын Цюрих хотын Технологийн Их сургуульд докторын зэргээ хамгаалсан. 2008 оноос эхлэн Швейцарийн Хөгжлийн Агентлагийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Ногоон алт” төслийн менежерээр ажиллаж байна.

Ж: Та саяхан Монгол Улсын өнөөдрийн бэлчээрийн байдлыг дүгнээд бүх нутгийн 60 хувь нь доройтолтой байна гэж хэлсэн. Энэ бүхний цаад шалтгаан нь бэлчээр хэнийх ч биш болчихсон байгаатай холбоотой гэсэн. Яагаад ингэж хэлэх болов?

Ц. Энх-Амгалан: Энэ асуудал миний төрсөн нутаг, өссөн орчин гээд миний амьдралын нэг хэсэг учраас 10 гаруй жил судалгааны ажил, төсөл хэрэгжүүлж ирлээ. Үндсэн хуулиараа бэлчээр төрийн өмч. Түүн дээр хувийн аж ахуй эрхлэгч малаа өсгөөд, үржүүлээд авч явж байгаа. Манай нийгэм монголын хөгжлийн зааг дээр байна гэж би боддог. Сүүлийн 25 жилд малын тоо өсч 60 сая боллоо гэж ихэнх хүмүүс хөгжиж дэвшиж байгаагаар харж баярлаж байгаа боловч малыг тэжээж байгаа бэлчээр нь талхлагдаж байгааг анзаардаггүй. Сүүлийн 8 жил явуулсан судалгаанаас үзэхэд нийт газар нутгийн 65 хувь нь доройтсон гэж үзэж байгаа. Доройтсон гэдэг нь юу гэсэн үг вэ гэхээр бэлчээр дээр байгаа ус, ургамал, хөрс, зэрлэг амьтдын амьдрах орчинд аюул тулгараад байна гэсэн үг. Орон нутагт аваад үзэхээр бэлчээрийн асуудлыг хэн хариуцах юм бэ? Малчид дээр очихоор “ер нь бол даац хэтрээд бэлчээр талхлагдаад байгаа” гэдгээс өөр зүйл хэлдэггүй, асуудлаа ойлгоод байгаа хэрнээ өөрсдийнх нь эрх, үүрэг гэдгийг мэддэггүй. Сум, аймгийн засаг дарга, хариуцаж байгаа мэргэжилтнүүдтэй ярилцахаар мөн олигтой юм мэддэггүй. Хууль эрх зүйн талаас нь судлаад үзэхээр манай нийт газар нутгийн 70 гаруй хувийг эзэлж байгаа бэлчээрийг зохицуулах хууль, эрх зүйн орчин байхгүй. Газрын хууль дээр хоёрхон заалт байдаг нь өвөл, хаврын бэлчээрийг малчид сайн дурын үндсэнд зохион байгуулалтад ороод ашиглаж болно гэсэн, иргэний хуульд байгалийн нөөцийг ашиглаж байгаа иргэн хүн тодорхой хэмжээний хариуцлагатай байна гэсэн заалтууд л байгаа. Бэлчээр гэдэг маань байгалийн нөөц, тэр дундаа ус, хөрс, ургамал, амьтдыг агуулж байдгийнхаа хувьд эдгээрт чиглэсэн олон хуулийн заалтуудад тусгагдаж өгсөн байх ёстой боловч орхигдсон байдаг.

Ж: Таны нийтлэлд гаргаж тавьсан асуудал нийтийн өмч бол хэний ч өмч биш юм билээ. 200 жилийн өмнө Англичууд ийм олон хоньтой байхдаа манайх шиг байдалд ороод ирэхээр өвөлжөөнөөсөө ижил тооны мал хамтын газар луугаа оруулдаг болёе гэсэн шийдэлд хүрсэн байдаг. Тухайн хүн ямар нэг хэмжээгээр илүү мал оруулах юм бол бусдынхаа эрх ашигт халдсан хэргээр хариуцлага хүлээнэ. Үүнийг монголын нөхцөлд яаж хийж болох вэ?

Ц.Энх-Амгалан: Үүн дээр сүүлийн 10 гаруй жил маш олон эрдэмтэд санал бодлоо уралдуулж сайн туршлагауд ч бий болж байна, муу туршлагауд ч бий болж байна. Бид бэлчээрийг зохицуулж, хяналт тавья гэхээр нүүдлийн аж ахуй хаа сайгүй нүүгээд явж байх ёстой тул болохгүй гэдэг. Уг нь нийгмийн хил буюу нэг айл үе удаараа нэг өвөлжөө, хаваржаандаа буусаар ирсэн, зөвхөн тэр хилийнхээ дотор

хөдөлгөөн хийдэг уламжлалт зохион байгуулалт бидэнд байгаа. Сүүлийн үед малчдад малаа өсгөөд байвал сайн гэсэн мессеж өгчихсөн тул бэлчээрийнхээ даацыг хэтрүүлж ашиглаад байгаа, энд л асуудал байна.

Ж: Нөгөө талаасаа хотод амьдардаг хүмүүс мал худалдаж аваад, өөрийн малчинтай болоод, нөгөө малчныхаа юу хийж байгаад хариуцлага хүлээдэггүй асуудал байгаа.

Ц.Энх-Амгалан: Сүүлийн 25 жил малчдад үүнийг ойлгуулаад, зохион байгуулж байгаа ажил байхгүй байна л даа. Тоглоомын дүрэм тодорхой биш болохоор малчид ойлголтгүй байна. Та мянгат малчин, би 207 малтай, нийлээд нэг хот айл бүрдүүлдэг байлаа гэж бодоход та илүү хариуцлага хүлээх ёстой. Энэ хоёр хүний харилцааг төрөөс зохицуулж өгөх хэрэгтэй болоод байна. Баг дотор яваад үзэхээр дөрвөн улиралд бэлчээрээ ашигладаг тодорхой хот айл, нэг нутаг усныхан гээд бүлгийн зохион байгуулалтад ороод яваад байгаа. Малчид хүлээгээд төрийн бодлого байхгүй болохоор өөрсдөө тодорхой арга хэмжээ аваад эхэлж байна. Энэ хэсэг газар бид зун, хавар байдаг юм аа, бэлчээрийнхээ сэлгээ, нүүдлийг ингэж зохицуулаад хэсэг хугацаанд ямар ч айл нүүж ирэхгүйгээр газраа амраая гэсэн зохион байгуулалтад орсон байдаг. Бид төрөөс эдгээр санаачлагуудыг нэгтгээд төрийн бодлогоор дэмжээд өгөөч, хэн ч төрийн газрыг хувьчлах тухай яриагүй байна аа гэдгийг хүсч байгаа юм.

Ж: Үүнийг зохицуулах өөр арга байж болох юм. Багуудын айлуудад өвөлжөөний газрыг өмчлүүлнэ, тэгэхдээ зарж болохгүй, зөвхөн үе удам дамжуулж ашиглах боломжтой. Өвөлжөөнөөсөө цааш адилхан тооны мал оруулна, илүү тооны мал оруулсан нь татвар төлнө.

Ц.Энх-Амгалан: Ер нь бэлчээрийн даац хэтэрсэн тухай малчид бүгд мэдлэгтэй болчихсон, тодорхой хэмжээний зохион байгуулалтад орчихсон байгаа. Малчид малынхаа тоог өөрсдөө цөөлнө гэхээр хэцүү учраас хуулийн механизмаар зохицуулж өгөх хэрэгтэй байгаа юм. Хоршоог бэлчээрийн зохион байгуулалттай холбоёе гэхээр итгэлцлийн асуудал яригддаг. Бид баруун аймагт 60 гаруй хоршоог идэвхжүүлээд, ажиллуулаад явж байгаагаас яг хоршоо гэдэг утгаараа хөгжөөд явж байгаа нь 30 гаруй л байна. Нэлээн туршлагатай хоршооны зөвлөх багшийн хэлснээр 3 төрлийн хоршоо илүү хөгжиж чадаж байгаа гэсэн. Үүнд хоршооны даргадаа итгэх итгэл сайтай, нэг нэгэндээ итгэдэг юмуу их хэмжээний дундын хөрөнгөтэй хоршоолууд багтаж байгаа юм. Малчдын үндсэн асуудал нь бэлчээр- бэлчээргүй бол малгүй, малгүй бол амьдрал нь оршин тогтнохгүй. Мал илүү гарлаа, зарьяа гэхэд мал нь өвчтэй учраас зах зээл байхгүй. Манай Баянхонгор аймгийн Богд сумаас л гэхэд нэг багаас 6000 хонь, ямаа зармаар байна гэсэн тооцоо гаргачихсан байхад авах үйлдвэр, үнэ тохиролцож байгаа хүн алга. Тэгэхээр нэг талаасаа хэдийгээр малчид бэлчээрийн даац хэтэрснийг ойлгож

байгаа ч зах зээл рүүгээ орохыг нь зохицуулах механизм байхгүй байгаа нь гарах шийдлийг хязгаарлагдмал болгож байгаа юм. Бусад орнуудын туршлагыг монголд авчрах нь буруу гэж бодож байгаа, яагаад гэвэл манай бэлчээрийн байгалийн өгөгдөл нь маш эмзэг, нийт хур тунадасны хэмжээ ердөө 250 мм. Ийм чийгшилтэй, дээрээс нь маш нимгэн хөрс учир элэгдэлд өртөмтгий гэж тодорхойлоод байгаа. Хамгийн удаан хугацаанд хэрэглэхийн тулд байнга сэлгэж, амрааж, өөрийнх нь нөхөн сэргэх чадварыг нь үлдээх маягаар явуулахгүй бол энэ өргөн, уудам газар нутгийг нэг цөлжүүлчих юм бол тэр чигтээ улаанаараа эргэлдээд дуусна гэсэн дүгнэлтийг гаргасан байдаг.

Ж: Та хөдөө орон нутагт Швейцарийн Хөгжлийн Агентлагийн 'Ногоон алт' төслийг хэрэгжүүлж байгаа менежер хүн. Танайхан бэлчээрийн хөрсийг амраагаад, өөрөөр нь нөхөн сэргээлж туршилтыг хаана хийсэн, ямар үр дүн гарсан тухай ярьж өгөөч.

Ц.Энх-Амгалан: Бэлчээрийн төлөв байдлын үнэлгээг 8 жилийн турш баг бүрт байдаг байгаль орчин хяналтын хүрээлэнгийн цэгээр хийсэн. Эдгээр 1500 цэгийн мэдээллийг нэгтгэснээр тухайн жилийн бэлчээрийн төлөв байдал, ургацын хэмжээг судалдаг бүтэц байсан. Багийн газар нутаг 10.000 га гэж үзэхэд тэр цэг маань тухайн газар нутгийг төлөөлөх чадвар нь харьцангуй бага учраас бид 600 цэгийг нэмж байгуулаад 2100 цэгээс, газар бүр дээр нь монгол эрдэмтэд (МУИС, ХААИС, УЦУБОХ, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын ажилтнууд) очоод судалгаа хийсэн.

Ж: Монгол улсын бэлчээрийн төлөв байдлын тухай сүүлийн 8 жилийн мэдээлэл бий болгочихсон, үүн дээрээ тулгуурлаад 65 хувь нь доройтолтой гэдгийг гаргаж ирсэн юм байна. Үүнийг сэргээхийн тулд хууль зүй, засаг захиргааны зохицуулалтын тухай ярилаа. Одоо байгаль орчных нь талаас ярья. Та тодорхой бэлчээрүүдийг хашиж байгаад амраах тухай бичсэн байна лээ, үүний хэрэгжилтийг би Баян-Өлгий явах замдаа харсан. Та өмнө ярьсан Английн жишээний тухай яриач.

Ц.Энх-Амгалан: Тухайн тосгон хязгаарлагдмал бэлчээрийн газартай байж л дээ. Тосгоны бэлчээрийн даац тодорхой хэмжээнд байх боловч малчин бүр өөрийнхөө эрх ашгийг бодно, тийм учраас малын тоо өссөөр, өссөөр нэг мэдэхэд бэлчээрийн даац хэтэрчихсэн байсан. Тосгоны захиргаанаас малчидтайгаа уулзаад бэлчээрийнхээ даацыг айл бүрт хувааж өгөх зөвшилцөлд хүрсэн байдаг. Илүү гарсан малынхаа төлөө хураамж төлснийг нь сан бүрдүүлээд өөр зүйлд хөрөнгө оруулалт хийх зөвшилцөлд хүрээд айл бүрт "тоон хязгаар" өгсөн байгаа юм.

Ж: Тэр нь бас малынхаа чанарт нөлөөлөөд олон тооны чанаргүй малын оронд том, чанартай мал нь ихсэж гарч ирсэн гэсэн үг. Одоо Америкийн энэ чиглэлээр Нобелийн шагнал авсан хүний тухай ярья.

Ц.Энх-Амгалан: Урьд нь бэлчээрийг хувьчилж, эзэнд газрыг ойртуулах нь сонгодог арга гэсэн урсгал нео-классик онол дээр явдаг байсан байгаа юм. Элинор Остром гэж эрдэмтэн нийтийн өмч гэж байлгаад, дундаа ч гэсэн тэр өмчийг зөв ашигладаг арга байна гэдгийг гаргаж ирсэн. Энэ хүний онол нь их сонирхолтой, дандаа бодит баримтуудыг судалж байж онолоо гаргаж ирсэн байгаа юм. Жишээлбэл, Непалд тариалангийн талбай яаж ашиглаж байгаа,

Швейцарьт Альпийн нурууны малчид яаж 500 жилийн турш газраа зөв ашиглаж ирсэн зэрэг дэлхий нийтийн дундын өмчийг ашиглаж ирсэн жишээг судлаад 8 зарчим гаргасан байгаа юм. Энэ 8 зарчим байгаа тохиолдолд хэдий бэлчээр нь дундын өмч ч гэсэн зөв зүйтэй ашиглах арга замууд байна гэсэн.

Ж: 8 зарчмаас нэг нэгээр нь дурдвал?

Ц.Энх-Амгалан: Хил, хязгаарыг нь тодорхой байлгаж. Энэ нь монголд тодорхой байгаа, бие биенийхээ бэлчээрийг мэддэг. Хоёрдугаарт түүнийгээ ашиглах дүрэм журам буюу нөөцийг ашиглах тухай тусгаж өгсөн. Монголын хувьд малчид би хэдэн сарын хэднээс хэднийг хүртэл байна гээд зохион байгуулалт нь байгаа.

Ж: Хил хязгаар, дүрэм журам нь тодорхой байх юм байна. Гуравдугаарт, бүх талуудын оролцоотойгоор газар ашиглалтаа шийдэж явъя гэсэн. Дөрөвдүгээрт, нийгмийн эзэмшлийн газар дээр ажиллаж байгаа бүх гишүүд дүрэм журмаа хүлээн зөвшөөрсөн байна. Үүнийг хянах хяналтын механизм байна, маргаан гарвал таслан зогсоох механизм байна. Эцэст нь, хариуцлагын механизм байх ёстой. Остронын хийсэн энэ дүгнэлт маш олон жилийн судалгаа, хөдөлмөрийн үр дүнд бий болсон, ямар ч оронд хэрэгжиж болохоор байсан тул Нобелийн шагнал хүртсэн байдаг. Энэ мэтээр хоёулаа дэлхий дахинд хийсэн туршлагуудын тухай ярилаа. Энэ дундаас монголчуудын хийж чадахгүй зүйл нь юу байна вэ?

Ц.Энх-Амгалан: Байхгүй. Зөвхөн төр нийтийн өмчийн бэлчээрийг яаж ашиглах ёстой талаар хууль, бодлогоо тодорхойлмоор байна. 25 жилийн турш бэлчээрийн хуулийн тухай төсөл УИХ-д удаа дараа өргөн баригдаад одоог хүртэл хэлэлцэгдээгүй, батлагдаагүй байна.

Ж: Яагаад тэгж байгаа юм бол?

Ц.Энх-Амгалан: Янз бүрийн шалтгаан байгаа. Малчдаас өөрөөс нь сонсохоор уул уурхай манай бэлчээрийг ашиглаж байгаа учраас уламжлалт эрхийг хүлээн зөвшөөрөхгүй байна гэж их гомдоллодог. Зарим эрдэмтэд манай нүүдлийн аж ахуйд маш болгоомжтой хууль эрх зүйн орчныг зохицуулахгүй бол болохгүй гэдэг. Манай УИХ дөрвөн жилийн хугацаатай учраас хууль зохицуулаад эхний жил нь өнгөрчихдөг. Хоёр дахь жилдээ хууль батлах дээр хэлэлцэх ёстой байтал сонгууль дөхөөд гишүүдийн маань анхаарал өөр зүйлд сарниад явчихдаг. Ингээд удалгүй төр засаг солигдоод энэ процесс маань дахин давтагдах учраас огт шийдэлд хүрч чадахгүй байгаа юм.

Ж: Өөр ямар шалтгаан байна? Иргэдээс хүсэхгүй байгаа зүйл байна уу?

Ц.Энх-Амгалан: Байхгүй. Бид бэлчээрийн хуулийн төслийг батлаад малчдаас судалгаа авахад батлуулаад өгөөч, тэр байтугай хураамж төлье гэсэн саналууд ирсэн.

2017.10.28

Дефакто ярилцлагын гол агуулгыг
хураангуйлан бэлтгэв.

Ярилцлагын бүрэн эхийг

<http://jargaldefacto.com/article/ts-enkh-amgalan-enkh-amgalan-tseelei> холбоосоор үзнэ үү.

ALL-NEW DISCOVERY
www.landover.mn



LAND ROVER
ABOVE & BEYOND

Вагнер Ази Автомотив ХХК
Нарны зам 55/1, Тээвэрчид гудамж, Сүхбаатар дүүрэг, Монгол улс, 14253
Холбоо барих: 70113673, 99106507, 99118375, 99118301

WAGNER
ASIA AUTOMOTIVE LLC



ДеФакто **ТОЙМ**

Ням гараг бүр VTV телевизээр 19 цагт гардаг Дефакто тоймын эмхэтгэл: 2017.12.10-ны дугаар

Долоо хоног бүрийн тойм, <http://fargaldefacto.com/category/12>

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ХОРИГИЙГ УИХ ХҮЛЭЭЖ АВСАНГҮЙ

2018 оны төсөвт тавьсан Ерөнхийлөгчийн хэсэгчилсэн хоригийг УИХ хэлэлцсэн бөгөөд гишүүдийн 82.4 хувь нь дэмжсэнгүй. Хоригийг хүлээж аваагүй учраас төсөв хүчин төгөлдөр хэвээр үйлчилнэ. Ерөнхийлөгч төсөвт хэсэгчлэн хориг тавихдаа “хэт үрэлгэн төсөв” гэсэн үндэслэл гаргасан байсан юм.

Тухайн улс ирэх жилдээ хийж бүтээх зүйлсийнхээ буюу ДНБ-ийхээ тодорхой хэсэгтэй тэнцэх хэмжээний татвар хурааж аваад түүгээрээ нийгэм эдийн засгийн хэрэгцээгээ хангахад зориулах төлөвлөгөөг төсөв гэдэг. Хөгжсөн орнууд төсөв нь ДНБ-ий 17-20 хувь байвал өгөөжтэй гэж үздэг бол хөгжиж байгаа оронд 30 орчим хувь гэж үздэг. Харин Монгол улсад бол 40 орчим хувь байдаг.

Төсөв өөрөө эдийн засгаас хамаардаг тул хөнжлийнхөө хэрээр хөлөө жийх гэсэн зарчмыг баримталдаг. Монгол улс 2012-2016 онд гурван ч төсөвтэй болсон байлаа. Үүнийг хянаж чадахгүй байсан ба Төсөв, Хөгжлийн банк, Монголбанк гэсэн гурван төсөв байсныг арай гэж гадаадын хөгжлийн институтүүдийн шаардлагын дор нийлүүлсэн.

Тэр үед төсвийн зөвхөн алдагдал нь л 17 хувь хүрч байсан юм. Өдгөө ЗГ, УИХ гэсэн 2 төсөвтэй байгаа. УИХ-ын гишүүд төсвийг захиран зарцуулах эрхээ хадгалсаар байгаа.

Монгол улс нэг л төсөвтэй, тэр нь ил тод байх ёстой. Хоёр төсөв хийж байна гэж Ерөнхийлөгч үзээд хорьсон хэдий ч хүлээж аваагүй. Сангийн сайд Ч.Хүрэлбаатар “төрийн мөнгийг төрийн сангаас гаргаад арилжааны банкуудад байршуулдаг болжээ” гэж хэлсэн. Тэр мөнгөө арилжааны банкуудад байршуулаад өндөр хүүтэй эргүүлж авдаг тогтолцоо тогтчихсон байна, энэ гажигийг засах болно гэж хэлж байгаа. Энэ нь Монгол улсын Засгийн газар арилжааны банкуудаар мөнгө хүүлж байна, аргаа ядсан байна гэсэн үг. Ч.Хүрэлбаатар сайд өөрийнх нь сайд байх хугацаанд төсвийг тодотгохгүй гэж хэлсэн мэдэгдэл нь нэлээд “чанга” мэдэгдэл байгаа юм. Учир нь Монгол улс төсвийг тодотгохгүйгээр урагшаа явж чадахаа больсон. Экспортын гол бүтээгдэхүүн болох нүүрс, алт, зэсийн үнэ өөрчлөгдөж байгаа нь асуудал ба дандаа хэрээс хэтэрсэн том зорилго тавьдаг учраас тодотгохгүй бол заримдаа их мөнгө ороод ирэхээр түүнийгээ үрэх гэж, бага мөнгө ороод ирэхээр үрэхгүй байя гэж тодотгодог.

Монгол улс нэгэнт хүзүүгээ тултал өрөнд орсон, үнэтэй зээлийг түүнээс үнэтэй зээлээр дарах бодлого явж байгаа. Гэрэгэ бондоор бол харин бага хүүтэй зээлээр санхүүжүүлж чадсан. 1-р сард 600 сая долларын бондыг төлөх ёстой ч түүнийг төлөхийн тулд 800 сая доллар босгосон ба 120 сая доллароор нь зарим бондоо буцааж авахгүй л байгаа. Ер нь Засгийн газар аажмаар бонд босгохдоо 100,200 сая доллароор илүү босгоод байгаа. Зээлийг зээлээр төлөх нь өр төлбөрөө барагдуулж байгаа хэрэг ердөөс биш, харин ч улам нэмээд байгаа юм. Хямдхан зээл олсон гээд баярлах хэрэг байхгүй ба учир нь асуудал түүндээ оршдоггүй. Бид яах гэж зээл авсныхаа учрыг бүрэн олохгүй л байгаа.

Төсөв нь үргэлж алдагдалтай, бид үргэлж өртэй, өр тавьсан хүмүүс нь өрөө төлдөггүй, өр тавиагүй бид төлдөг. Тэгээд л татвар нэмээд “өдийг нь зулгааж байгаа шувуу шиг” амьдарч байна шүү дээ.

МОНГОЛ УЛС ЕВРОПЫН ХОЛБООНЫ ХАР ЖАГСААЛТАД БАГТЖЭЭ

EU LIST OF NON-COOPERATIVE TAX JURISDICTIONS		
American Samoa	Macao SAR	Saint Lucia
Bahrain	Marshall Islands	Samoa
Barbados	Mongolia	Trinidad and Tobago
Grenada	Namibia	Tunisia
Guam	Palau	United Arab Emirates
Korea (Republic of)	Panama	

[Гэрэл зургийг ec.europa.eu](http://ec.europa.eu)

Европын холбооноос 17 бүсийг хар жагсаалтад орууллаа. Жагсаалтад оруулахдаа тухайн орны татварын бодлого хэр нээлттэй, мөн бусад орны компаниудад онцгой бага татварын нөхцөл олгодог эсэх зэрэг үндэслэлээр гаргасан гэнэ. Гэхдээ Европын холбооноос эдгээр орнуудын эсрэг ямар бодлого хэрэгжүүлэх нь тодорхойгүй байна.

Монгол улсын татварын бодлого дөрвөн арвын зарчмаар явдаг. Нийгмийн даатгал, орлогын татвар зэрэг бүгд 10 хувь байдаг. Дэлхийн бүх орнууд хоорондоо гадаадын хөрөнгө оруулагчийг татахын тулд өрсөлддөг. Энэ өрсөлдөөнийг ямар ч Европын холбоо зогсоож чадахгүй. Монгол улсын 10 хувийн зарчимд өөрчлөлт орж байгаа. Шинэ оноос 1.5

сая төгрөгийн цалинтай хүний орлогоос 25 хувийн татвар авах болж байгаа. Энэ бол дэндүү доогуур босго буюу ойролцоогоор 600 доллар. Жилд 7200-оос дээш долларын орлоготой хүнийг хэт өндөр орлоготой хүн гэж үзээд татвар авч байгаа юм. Хүн амаа хөгжүүлэх, хүмүүсээ баян болгохыг дарамталсан ийм татварын бодлого гаргаад өмнөх Засгийн газар яваад өгсөн. Энэ Засгийн газар нь үүнийг биелүүлнэ гээд сууж байна.

Европоос ийм хар жагсаалтад орсон Нидерланд, Мальт, Люксембург, Ирланд гэх мэт улсууд байгаа. Монгол Нидерландтай давхар татварын гэрээ байгуулсан ба монголд бүртгэлтэй гадаадын компаниудын бараг хагас нь Нидерландад бүртгэлтэй. Учир нь бид Нидерландтай давхар татвар авахгүй гэсэн гэрээтэй. Нууц мөнгөөр терроризмыг санхүүжүүлж байна гэж үзэж байгаагаас болоод шаардлага нэлээд өндөрсөөд байна л даа. Зарим оронд бол бүр гадаадын хөрөнгө оруулалттай компаниас орлогын татвар авахгүй гэсэн заалт хүртэл байна. Манайх тэдэнтэй харьцуулахад гайгүй ба Европын холбоо өөрөө ч өөртөө шаардлага тавих хэрэгтэй.

Энэ хэвээр байвал Европын Холбооноос тусламж өгөхгүй гэж ярьж байгаа. Үүнийг хаягласан, тодорхой уулзалтуудыг Сангийн сайд удалгүй хийнэ гэж яригдаж байна. Гэхдээ манайх хар нэрсэд орохдоо хамгийн хар дээр нь ороогүй байх гэж бодож байна. Цаазын ялыг сэргээх яриа гарсантай холбоотой гэж бодохгүй байгаа.

“Монголын зэс корпораци”

ДЭЭД ШҮҮХЭД ЯЛЛАА

2017 оны 03 дугаар сарын 29-ний өдөр Эрдэнэтийн төлөөлөн удирдах зөвлөлийг 100 хувь төрөөс бүрдүүлэх шийдвэрийг УИХ, ЗГ-аас гаргасан. Уг хэргийн шийдвэр хоёр шатны шүүхээс “Монголын зэс корпораци”-ийн талд гарсан бөгөөд энэ сарын 07-ны өдрийн Дээд шүүхийн шийдвэр мөн уг компанийн талд гарчээ.

Энэ бол манай засаглал хэр зэрэг боловсронгуй биш байгааг харуулж байгаа үйл явдлын нэг. “Монголын зэс Корпораци” тодорхой компанийн 49 хувийг эзэмшиж байгаа юм байна. Гэтэл тэр 49 хувийг нь их хурал шийдвэр гаргаад хурааж авч байгаа юм. ТУЗ-ийнх нь бүх хүмүүсийг хөөж явуулаад, өөрсдөөсөө хүн сонгоод, 100 хувь улсын хөрөнгө гэж хэлээд байгаа үйл явдал юм л даа.

Ямар ч шалтгаан байсан аль нэг хувийн хуулийн этгээдийн хөрөнгийг УИХ, Засгийн газар тогтоол гаргаад авчихаж болохгүй. Аливаа нэг компанийг УИХ, Засгийн газар тогтоол гаргаад авчихаж болдог юм бол хувийн өмчийн баталгаа гэдэг зүйл алга болно.

Яг ийм шийдвэрийг шүүх өөрөө гаргасан бол өөр асуудал болж хувирна.

Тиймээс үүнд хоёр асуудал байгаа юм. Нэгдүгээрт хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглал холилддоод хэн нь юу дуртайгаа хийгээд байдаг болжээ гэдэг нь харагдаж байна.

Ийм учраас хуулийнх нь зүгээс буюу номын дагуу “хууль ёсны биш” гээд шийдвэрлэж байгаа юм.

Оросуудаас 49 хувийг аль нэг монгол компани авсан, тэр үеийн удирдлагууд нь оролцсон, хуйвалдсан гэх мэт нь бол нэг яриа. Гэмт хэргийн чанартай гол зүйл нь энэ биш. Харин Худалдаа Хөгжлийн Банкны эзэн хадгаламж эзэмшигчдийнхээ мөнгийг нэг талаас нь, Бондын мөнгөнөөс 500 саяыг хуурамч гэрээгээр гаргаад юм худалдаж авсан гэдэг нь хууль бус асуудал. Үүнийг их хурлын гишүүн Т.Аюурсайханаар ахлуулсан ажлын хэсэг батлаад, тайлангаа улсад тавьсан л даа. Энэ тухай ярилгүй, ТУЗ сольсон, гурван шатны шүүхээр яваад байгаа зэрэг нь санаатай хийгээд байгаа үйлдэл шиг байгаа юм. Арилжааны банк хадгаламж эзэмшигчдийнхээ мөнгөөр юу дуртайгаа хийгээд байгаа нь л гол хууль бус асуудал байна. Гэтэл Т.Аюурсайханы тайлан ч яригдахаа байлаа, энэ маягаар шал өөр зүйл “хөөлгөөд” явуулчихлаа л даа.

Банкныхан МУ-ын төрд маш хүчтэй нөлөөтэйг харуулж байна. УИХ-ын гишүүд, хоёр нам нь маш их санхүүжилт, зээл банкнаас авсан бололтой харагдаж байна. Ийнхүү харилцан барьцаалсан байгаа нөхцөлд бүх юм явагдаж байна. Хараат бус хуулийн засаглал төлөвшиж өгөхгүй байгаагаас болж энэ олон авлигын хэргүүд сонин дээр хоёр өдөр шуугиад чимээгүй болж байна. Жишээ нь нэг хэсэг нөхдийг хэрэг хийсэн гээд Авлигатай тэмцэх газар баривчлахаар, прокурор нь буруу байна гээд чөлөөлдөг. Ингээд бидний өмнө муур хулгана болж, шударга үнэний дүрд тоглосон хариуцлагагүй үйл явдлыг үргэлжлүүлж байна. Одоо байгаа хүмүүсээ хянаж чаддаг, намын санхүүжилтээ тайлагнадаг болтол энэ жүжиг хэзээ ч дуусахгүй.

ШИНЭ ТӨРЛИЙН ҮЛЭГ ГҮРВЭЛИЙГ ИЛРҮҮЛЖЭЭ

Өнөөгийн монголын газар нутагт 71 сая жилийн өмнө амьдарч байсан гэх өвөрмөц динозаврыг эрдэмтэд нээж илрүүлжээ. Энэхүү динозавр нь хоёр хөлт, махан идэшт, усанд сэлдэг үлэг гүрвэл байжээ. Уг олдворыг монголын өмнөд хэсгээс Хятад улсаар дамжиж Европ руу гарсан байх гэж хүмүүс таамаглаж байна. Уг олдвор “Ухаа толгод” гэдэг газраас анх олдож байжээ.

Энэхүү амьтны дүрсийг “The Guardian” сонинд харуулсан байсан. Монголын “Ухаа толгод” гэдэг газраас нууцаар хилээр гаргасан гэж яригдаж байгаа. Үүний цаана МУ-ын хил хязгаар аль зэрэг баталгаатай вэ гэсэн асуудал гарч ирнэ. 71 сая жилийн өмнө нисдэг байсан амьтан МУ-ын хилээр нисээд гарчихмааргүй юм. Монголын хилээр юм болгон гараад явчихдаг ямар учиртай юм? Хоёр жилийн өмнө Хятадын гаалийнхан вагонд хүний цогцос байна шүү дээ гэж МУ-д мэдэгдэж байсан. Түүнийг хэн болох, яагаад байсан тухай хэн ч яриагүй. Батаар бас л өөрөө нисээгүй байлтай, гарч яваад баригдаад буцаж ирсэн. Монголын хилээр энэ бүхэн гараад байхад гааль юу хийж байгаа, ард түмэнд яагаад мэдээлэхгүй байгаа юм бэ.

Саяхан Цагаан хаднаас хууль бус зүйл хилээр гаргаад байна гээд хилээ хаана гэж Хятадын тал мэдэгдэл хийсэн. Цагаан хаднаас ямар хууль бус зүйл гарсан талаар монголын төр чив чимээгүй. Наана нь 6000 хүн оочирлон зогсож байна шүү дээ.

Дефакто тоймын гол агуулгыг хураангуйлан бэлтгэв.

Тоймын бүрэн эхийг

<http://jargaldefacto.com/article/defakto-toim-2sh17-12-1sh> холбоосоор үзнэ үү.




Photo credit to theguardian.com



NEW NISSAN **PATROL**



☎ 9911-0014, 9911-5140, 9910-0167

ЛИЗИНГИЙН НӨХЦӨЛ:

Урьдчилгаа **0%**

Хүү **1.4%**

Хугацаа **84 сар**

УРАМШУУЛАЛ:



Хамгаалалтын хууль



Саргал оворын эрх



4x4 бөлийн дугуй



Салын шилний хамгаалалт

ҮНЭ: ₮214.0 сая



JARGAL DEFACTO

ГАР УТАСНЫ АППЛИКЭЙШН

Та “Дефакто Газет” цахим сонинг тогтмол төлбөргүй хүлээн авахыг хүсвэл www.jargaldefacto.com болон www.defacto.mn вебсайтад өөрийн имейлээ бүртгүүлнэ.

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Дамбадаржаагийн Жаргалсайхан
Дангаасүрэнгийн Энхбат

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАГ

Ерөнхий редактор: Ганбаатарын Жавзмаа
Баг: Батхүүгийн Амар
Отгонсүрэнгийн Билгүүн
Өсөхбаярын Биндэръяа
Адъяагийн Тунгалаг

ХОЛБОО БАРИХ

✉ editor1@jargaldefacto.com
✉ +976 94109342
🌐 www.defacto.mn